



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан ажлын хэрэгцээнд зориулан 76,000,000.00 (далан зургаан сая) төгрөгт багтаан 4 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлтийг хавсралтаар тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦӨТТЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001717

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
146 дугаар тогтоолын хавсралт



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХУДАЛДАН АВАХ
АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Автомашинны техникийн үзүүлэлт	Тоо ширхэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1500 cc	4	19 000 000,00	76 000 000,00
	ДҮН	4	19,000,000.00 (арван есөн сая)	76,000,000.00 (далан зургаан сая)